



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/177

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 13 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын 10, 14 дүгээр багийн “Баг хөгжлийн төв”-ийн байрны гадна болон дотор талд байрлуулах камер худалдан авах зардалд 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлын 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг “Эрх зүй нийгмийн хэв журам хөтөлбөр”-ийн “Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах арга хэмжээний” зардлаас гаргаж, Мөрөн сумын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6713010564